



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар

1104

Амардалай

Залуучуудын хөгжлийг дэмжих салбар
зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 5.2.8, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутагт залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, эрхийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагаа, идэвх санаачилгыг дэмжин ажиллах залуучуудын салбар зөвлөлийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг салбар зөвлөлийн гишүүд, нийгмийн бодлогын мэргэжилтэнд, үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, дэмжин ажиллахыг Багийн Засаг дарга нар, байгууллага, аж ахуй нэгжийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3.Залуучуудын идэвх санаачилгаар явуулж байгаа ашгийн төлөө бус нийтэд тустай үйл ажиллагааг дэмжих зорилгоор Залуучуудын өдрийг сар бүрийн 3 дахь 7 хоногийн Баасан гаригт зохион байгуулахаар зарласугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2021 оны А/73, А/116 тоот захирамжуудыг хүчингүй болгосонд тооцсугай.


5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Золжаргал)-д даалгасугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ



Сумын Засаг даргын 2023 оны 01 сарын 11-ний
өдрийн А/04 дугаар захирамжийн хавсралт



1. М.Баярсүх (Засаг дарга, ЗХДСЗ-ийн дарга)
2. Л.Золжаргал (Засаг даргын орлогч, ЗХДСЗ-ийн дэд дарга)
3. Б.Сармандах (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
4. Б.Довуучий (Баянбулаг багийн Засаг дарга)
5. Б.Ууганбаатар (Хэсгийн цагдаа)
6. А.Мядагмаа (ЕБСургуулийн багш)
7. Ө.Пүрэвсүрэн (ЕБСургуулмын багш)
8. Б.Эрдэнэцэцэг (ЕБСургуулийн номын санч)
9. Ц.Нарантуяа (Хүүхдийн цэцэрлэгийн багш)
10. Ц.Цэцэгмаа (Хүүхдийн цэцэрлэгийн багш)
11. Э.Бүжидмаа (Хүүхдийн цэцэрлэгийн багш)
12. Э.Ганбодь (Хүүхдийн цэцэрлэгийн багш)
13. Н.Базаррагчаа (ЭМТ-ийн сувилагч)
14. Н.Түдэвдагва (Соёлын төвийн мэргэжилтэн)
15. Э.Хүрэлхүү (Төрийн банкны теллер)
16. Ц.Шаравдагва (ДУЦТСС-ын Шуурхай үйлчилгээ засварын техникч)
17. Д.Тэмүүлэн (Хувиараа хөдөлмөр эрхлэгч)
18. Н.Баттулга (Хувиараа хөдөлмөр эрхлэгч)
19. Л.Төмөрчөдөр (Цахиурт багийн малчин)
20. А.Батболд (Дэлгэр-Эмт багийн малчин)
21. Д.Отгончимэг (Цахиурт багийн малчин)
22. Б.Дагийжанцан (Баянбулаг багийн малчин)
23. А.Өлзийжаргал (Баянбулаг багийн малчин)